

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын  
2022 оны 06 дугаар сарын мэдээ

2022.06.24

**Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

**а/ Сумын ИТХ-ын чиглэлээр:** Олон улсын эмэгтэйчүүдийн баярын өдрийг тохирлдуулан ИТХ-ын ажлын албаны ажилчдын хүүхдүүд болон сумын хөгжлийн бэрхшээлтэй, амжиргааны түвшин доогуур 30 өрхийн хүүхдүүдэд ИТХ-ын даргын гарын бэлгийг гардууллаа.

Сумдын ИТХ-ын ажлын алба, ИТХ-ын төлөөлөгчдийн туршлага солилцох нөхөрсөг уулзалт арга хэмжээ Уулбаян суманд зохион байгуулагдаж сумын ИТХ-ын ажлын алба, төлөөлөгч нар нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцлоо.

Сумын ИТХ-ын хагас жилийн ажлын тайлан, ГУССЗ-ын хагас жилийн ажлын тайлан мэдээг хугацаанд нь холбогдох газарт хүргэж ажиллаа.

Баяндэлгэр сумын “Төлчин эмэгтэйчүүд”ийн чуулга уулзалтыг ИТХ,ЗДТГ-тай хамтран зохион явууллаа.

**б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:**

Тухайн сард дээд газраас 12 албан бичиг ирсний 6 нь хариутай, 2–нь хугацаандаа, 4–нь хугацаа болоогүй байна.

Сумын засаг даргын 05 дугаар сарын 18-ны өдрийн А/74 тоот захирамжаар сумын хэмжээний нийт өрхийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, тохижилт бүтээн байгуулалт, ногоон байгууламж, хог хаягдал, ажлын шинэ санал санаачлагыг дэмжих, иргэдийн ая тухтай таатай орчинд ажиллах амьдрах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр “Хашаандаа сайхан амьдарцгаая” болзолт уралдааныг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 2 үе шаттайгаар зохион байгуулахаар зарласан.

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилга, Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулж буй “Илүүдэл жингүй Эртэч монгол” аян болон Сумын ИТХ-аас албан байгууллага, багуудын дунд зарласан “Архигүй Баяндэлгэр” аяны хүрээнд ЕБСургуулийн 6-8 дугаар ангийн сурагчдад гар зургийн уралдааныг зохион явуулж дүгнэсэн. / Шагналын 235.000 төгрөгийг засаг даргын нөөц сангаас зарцуулсан./ Мөн “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” -ийг тохиолдуулан ЕБСургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Сагсан бөмбөгийн тэмцээн, 6-8 дугаар ангийн сурагчдын дунд “Унадаг дугуй” –н тэмцээнийг тус тус зохион байгуулсан. Шагналд шаардагдах 1.485.000 төгрөгийг засаг даргын нөөц сангаас зарцуулсан. Мөн энэ үеэр Улс бүсийн чанартай тэмцээнд өндөр амжилт үзүүлэн шагналт байрт шалгарсан багш сурагчдыг шагнаж урамшуулсан.

Сумын засаг даргын 2022 оны 06 дугаар 17-ны өдрийн А/85 тоот захирамжаар Мал аж ахуйн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэн тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж зөвлөгөөнөөс гарсан оновчтой саналуудыг орон нутгийн салбарын шийдвэрт тусган хэрэгжүүлэх зорилгоор суманд “Төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт зохион байгуулсан.

Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг сумын засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/86 тоот захирамжаар 06 дугаар сарын 06-19 өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

**Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр:** - 2022 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

- Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг, тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу эхний 6 сар бүрэн олгогдсон.

- Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн .

- Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан.

2022 оны Хөдөө аж ахуйн,орон нутгийн өмчийн ээлжит тооллогийг комиссын бүрэлдэхүүний хамт программд шивж статистикийн хэлтэс тушаахад бэлэн болгосон.

Төсөвт байгууллауудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Төсөвт байгуулага, татварын орлогын дансанд гарын үсгийн баталгааг авч натиротоор баталгааж, цахим мэдээллийн системд оруулсан

**Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:** Хөдөөгийн багийн ИНХ-уудад оролцож E-Mongolia системд нэвтрээд буй үйлчилгээ, систем ашигласны давуу тал зэргийг сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. Багуудын ИНХ-д оролцсон нийт 250 гаруй иргэнд мэдээлэл хүргэлээ. Мөн төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад танилцуулга, сурталчилгааны ажлыг хийсэн. Үүнд 200 гаруй төлчин эмэгтэй хамрагдсан болно. Чуулганд оролцогчид бүгд цахим төрийн үйлчилгээг авч чаддаг Цахим Баяндэлгэр болох уриалгийг дэмжлээ.

**Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

**Ерөнхий боловсролын сургууль:** Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх “Гүйцэтгэлийн үнэлгээ”-ний шалгалт 05 дугаар сарын 24-нөөс 05 дугаар сарын 27-ны өдөр хүртэл 1-12 дугаар ангийн сурагчдыг түүврийн аргаар сонгон авч зохион байгуулагдлаа.

Сүхбаатар аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 05 дугаар сарын 26-ны өдөр ЕБС-ийн сурагчдын эцэг эх, сурагч, Гэрэлт ирээдүй бүлгэмтэй уулзалт хийж, сургалт зохион байгуулагдлаа.

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 05 сарын 30-ны өдөр 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Сагсан бөмбөг”-ийн тэмцээн, 6-8-р ангийн сурагчдын дунд унадаг дугуйн тэмцээнийг зохион байгууллаа.

Анги дэвших болон улсын шалгалт 06 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл үргэлжиллээ.

2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр төгсөх ангийн сурагчдад гэрчилгээ гардуулах ёслол боллоо. 2022 оны 06 дугаар сарын 03 болон 15,20-ны өдрөөс нийт багш нар амарлаа.

06 дугаар сарын 22-ны өдөр Азиа Италия төрийн бус байгууллагаас Сүхбаатар аймгийн 13 сумын боловсролын байгууллагад IT, мэдээлэл зүйн чиглэлээр багш сурагчдыг чадавхжуулах, тоног төхөөрөмжөөр хангах чиглэлтэй төсөл хэрэгжих судалгааны ажлаар судалгааны ажилтан ЕБС-ийн захиралтай уулзалт хийлээ.

**Эрүүл мэндийн төв:** “Элэг бүтэн Сүхбаатар хөтөлбөр”-ийн хүрээнд 2017 оноос хойш хамрагдаагүй иргэдийн судалгааг нэгдсэн байдлаар гаргаж “Вируст гепатит элэгний хавдарын эрт илрүүлэг” төслийн хүрээнд 250 хүнд В,С вирусын шинжилгээ хийсэн.Шинээр 26 вирустай иргэдэд үзлэг хийж заавар зөвлөгөө өгөв. Мөн төслийн хүрээнд нийт 218 хүнд үзлэг шинжилгээ хийж шинээр элэгний хавдар 2,

элэгний хатуурал 3, элэгний дахисан хавдар 1, бөөрний сүрьеэ 1 шинээр оношилж 2 болон 3-р шатлалд шилжүүлэв.

Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтанд 3 их эмч, лаборант, 1 багийн бага эмч, сувилагч 2 хамруулав.

Хөдөөгийн 5 багт эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулж ирсэн иргэдийг дотор, хүүхэд, эмэгтэйчүүдийн үзлэгт хамруулж, хэвлийн эхо, зүрхний цахилгаан бичлэг гэсэн 2 багажийн шинжилгээнд хамруулав. Мөн эрсдэлт бүлгийн иргэдээс серилогийн шинжилгээ авсан.

**Соёл:** Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан 40 хүүхдийн бүрэлдхүүнтэй “Урам хайрла” тоглолтыг хүүхэд багачууд ард иргэдэд тоглолоо. Хамрагдагсад-70

“Алдарт эх” одон гардуулах ажиллагаанд зориулсан “Одонгоо зүү ээжээ” хүндэтгэлийн тоглолт зохион байгууллаа. Хамрагдагсад-120

Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор Үдшийн цэнгүүн 5 удаа зохион байгууллаа. Хамрагдагсад-164

Хонгор, Дэлгэр, Төв багт Эрүүл мэндийн төвтэй хамтран өдөрлөг зохион байгуулж ард иргэдэд соёл урлагийн явуулын үйлчилгээ явуулын номын сан, угийн бичгийн сургалт, АХА тэмцээн, хөгжөөнт буухиа тэмцээн, өдөрлөг цэнгүүн зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгууллаа. Хамрагдагсад-278

**Цэцэрлэг:** Хичээл сургалтын үйл ажиллагаа дуусч 6 дугаар сарын 6 -нд багш ажилчдын 2021-2022 оны хичээлийн жилд хийсэн ажлын гүйцэтгэлийн тайланг дүгнэсэн.

Уг үйл ажиллагаагаар сурагчдын болон багш ажилчдын ахиц дэвшил, алдаа оноогоо хэлэлцэж ирэх хичээлийн жилд юун дээр илүү анхаарч ажиллах талаараа хэлэлцүүлэг ярилцлага хийсэн бөгөөд энэ хичээлийн жилийн ажлын гүйцэтгэл маш сайн үнэлгээтэй дүгнэгдлээ.

Туслах багш, захиргаа аж ахуйн ажилчид хамтран хүлэмжинд 5 төрлийн нарын ногоо, ногооны талбайд 4 төрлийн төмс хүнсний ногоо тарьж үрслүүлээд байна.

Цэцэрлэгийн хашаа болон ногоон байгууламжийн хашааг будаж өнгө үзэмжийг сайжруулсан.

Бүлгийн багш нарын ээлжийн амралт 6 дугаар сарын 6 -нд эхэлсэн бол туслах багш, захиргаа аж ахуйн ажилчид 6 дугаар сарын 13 -наас ээлжийн амралтаа авч хуваарийн дугуу амарч байна.

Зуны сургалтыг Хонгор болон Ширээт баг дээр тус бүр 20 хүүхэдтэйгээр хичээллүүлж эхэллээ. Зуны сургалтын үйл ажиллагаа жигдэрсэн ирц 92%-тай байна.

**Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:**

**Байгаль орчин:** Сумын төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад оролцож, чуулганд оролцсон 200 гаруй эмэгтэйд тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах ажлын талаар сурталчлан таниуллаа. Мөн байгаль орчны нөхөрлөлийн талаарх ойлголтыг өгч ажиллаа.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх анхан шатны бэлтгэл ажил 1000 багш бэлтгэх сургалтад хамрагдаж байна.

Ногоон байгууламжийн усалгаа арчилгааг хариуцан ажиллаж модны ургалтын хувь 86 хувьтай байна.

**Хөдөө аж ахуй:** Сумын үхэр сүргийг махны чиглэлээр сайжруулах зорилгоор Сэлэнгэ үүлдрийн үхрийн өсвөр хээлтүүлэгч 8 –ыг 6 багийн малчдад олгосон.

2022 оныг хоршоог дэмжих жил болгосонтой холбогдуулан 5 хоршоог шинэчилсэн бүртгэлд хамруулж, суурь мэдээллийн судалгааг гаргаж аймгийн ХХААГазрын мэргэжилтэнд хүргүүлсэн.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан " Жижиг, дунд үйлпвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"--ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд жилийн 3% -ийн хүүтэй 5 жилийн хугацаатай үйлдвэр,үйлчилгээний ангиллаас хамаарч 20 -800 сая төгрөгийн зээлийн төсөлд хамрагдах талаар мэдээллийг өгч ажиллалаа.

Аймгийн МХГ- тай хамтран “Түмэндээ ээлтэй Төрийн хяналт” өдөрлөгийг зохион байгуулж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг цахимаар бүртгэх талаар мэдээлэл өгч мэдээллийн санг цахим үйлчилгээний нэгдсэн системтэй холбож аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод хүргэх талаар заавар зөвлөгөө өгсөн. Мөн хүнсний аюулгүй байдалд хийж буй хяналт, шалгалт тулгамдсан асуудал шийдвэрлэх арга замын талаар мэдээлэл хийсэн.Тус өдөрлөгт 78 иргэн хамрагдаж зөвлөгөө авсан.

Төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулж, 2022 онд дэвшүүлсэн зорилго зорилт, мал аж ахуйн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ,хуванцар савны хэрэглээ эрүүл мэнд нийгмийн даатгал, иргэний бүртгэл, татварын бодлого, e-mongolia цахим системийн талаар мэдээлэл хийлээ. Тухайн чуулга уулзалтаас дараахь уриалгыг гаргасан.

- Цахим орчинд эерэг хандлага түгээж нийгэмд манлайлал үзүүлье.
- Хуванцар савнаас татгалзъя. /2022 онд нийт өрхийн 60% -аас доошгүй нь хуванцар савнаас татгалзаж модон болон төмөр сав ундны усны хэрэгцээнд хэрэглэдэг болъё.
- Хоггүй баг, айл өрх болъё.
- Монгол улсын Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн “ Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд малчин өрх бүр ам бүлийн тоогоор 5 хүртэл мод тарьж ургуулах.
- Малын гаралтай түүхий эдийг өрхийн хэрэглээнд бүрэн ашиглацгаая.
- Техник хэрэгсэлээр мал хариулдаг байдлаас татгалзаж морь,тэмээг уналга эдэлгээнд сургаж ашиглацгаая.
- Айл өрх, иргэн бүр сүү цагаан идээ боловсруулах арга ажиллагаа, үндэсний өв уламжлалаа сэргээе . /хүүхэд багачуудад зааж сургах ,үлгэрлэх /. Өөр хоорондоо туршлага солилцох.
- Малын тооноос чанарт илүү анхаарч ажиллая/ Малын удмын санг хадгалах өөр хооронд нь үржил селекцийн ажлыг хийх, өөрийн сууриас хээлтүүлэгч тавихгүй байх. /
- Үндэсний хувцасаа хэрэглэж хэвших . / баяр наадам , хурал цуглаан овоо тахилга г.м/
- Өрх бүр үйлдвэрлэгч байж өөрийн бренд бүтээгдэхүүнтэй болох.

Мал төллөлт, бойжилт, том малын хорогдлын мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр ХХААГазарт, сарын эцэст статистикийн хэлтэст программд шивж орууллаа.

Том малын хорогдол бүгд 281, тэмээ – 1, адуу- 9, үхэр- 22, хонь- 123, ямаа- 126 нийт малын 0,05% нь хорогдсон байна.

Мал төллөлт бүгд 186458, ингэ- 167, гүү- 5861, үнээ- 8082, эм хонь- 109584, эм ямаа- 62764 буюу нийт малын 81% төллөсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын , үзлэг тооллого зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан байгууллагын эзэмшилд байгаа 14 худаг, 22 барилга байгууламжийн мэдээллийг санхүүгийн тайлантай тулгаж цахим системд оруулсан.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн